

Манмин Мэдээ

№ 67 2018 оны 12 сарын 23

‘2018 Дэлхийн Христийн нэвтрүүлгийн удирдагчид чуулсан зөвлөгөөн’-д оролцож Израйль Иерусалимд Манмины үйлчлэлийг дамжуулан буй GCN телевиз



2018оны 10-р сарын 14-нөөс 17ныг хүртэл ‘2018оны Дэлхийн Христийн нэвтрүүлгийн удирдагчид чуулсан уулзалт’ Израйль улсын Иерусалимд болж өнгөрлөө. Дэлхийн өнцөг булан бүрээс 35орны 180-д удирдагч нар оролцсон ба урилгаар GCN телевизийн захирал Ким Жин хүн ахлагч оролцож Манминий үйлчлэлийн талаар дамжуулсан юм.

10-р сарын 14ний өдөр үдээс хойш хүлээн авалтанд Израйлийн ерөнхий сайд Беньямин Нетаняху нь “Хувиршгүй туштайгаар Израйлийг хайрладаг Христийн байгуулагууд ялангуяа телевизийн нэвтрүүлэг Христийн контент бэлтгэн түгээдэг

телевизүүдэд гүн талархал илэрхийлж байна” гэсэн бол энэ зөвлөгөөнд АР (Эй Пи), Ройтер зэрэг дэлхий хэмжээний хэвлэл мэдээлэлийн байгуулагын удирдах ажилтнууд цугларч халуун уур амьсгалтай байлаа (Зураг 1, 2).

10-р сарын 15ны өдөр Ким ахлагч оройн зоог болон хүлээн авалтад оролцож, Иерусалим хотын дарга Нир Баркат болон бусад Христийн телевизүүдийн удирдагч нартай нөхөрлөж, 10-р сарын 16ны өдөр Израйлийн Рүбэн Риблин ерөнхийлөгчтэй Ерөнхийлөгчийн ордны ёслол хүндэтгэлийн танхимд болсон хүлээн авалт болон үдийн зоогонд оролцсон юм (Зураг 3). Мөн

энэ өдрийн үдээс хойш Израйлын парламентын ордонд зочилж, Юули Ёозл Еделстен парламентийн даргатай уулзсан юм. Үүний гадны зочидтой хамт оройн зоог барьсан ба энэ үеэр парламентийн дэд дарга Иехэл Хилик Бар И Жей руг пастораар дамжуулан авсан ивээл болон манмины үйлчлэлийн талаарх танилцуулсан юм.

10-р сарын 17ны өдөр хаалтын үйл ажиллагаанд Ничан Чэн төрийн нарийн бичгийн дарга “GCN телевизийн нэвтрүүлгийн үйлчлэлд Израйльд нэн хэрэгтэй бөгөөд энэ тал дээр идэвхитэй хамтран ажиллах болно” гэж дахин дахин талархалаа

илэрхийлж байлаа. Үүнээс гадна 2020оны 6-р сарын эхээр болох дэлхий даяарх христийн нэвтрүүлэгчид болон итгэгчид цугларч нэгдсэн чуулганыг Пентекостын өдөр буюу Ариун Сүнс бууж ирсэн өдрийг тохиолдуулан хийх ба энэ үйл ажиллагаанд манай сүмийн магтаалын багийг мөн оролцохыг урьсан юм.

‘2009онд И Жей руг пасторыг урьсан Израйлын нэгдсэн их цуглаан’-ны дараа И Жей руг пастор нь Израйльд үргэлжлүүлэн сайн мэдээний үйлчлэлээ хийсээр ирсэн ба үүний үр дүнд Израйльд христэд итгэгчдийн байр суурь өсөж өдрөөс өдөрт өргөжин тэлж сэргэлт явагдсаар байгаа юм.

Ярилцлага

“Колумбийн ард түмнийг сэргээж өгсөн амийн үг сургаальд талархаж байна”

Енласе Колумбиа телевизээс И Жей руг докторын сургаалийг долоо хоногт Зудаа нэвтрүүлж байгаа юм. Энэ нь Колумбийн ард түмэнд асар их нөлөө үзүүлж байгаа юм. Колумбийн орон нутгийн өнцөг булан бүрээс гэрчлэлтэй хамтаар сургаалиар дамжуулан их ивээл авсан тухай захидлууд ирсээр байдаг.

И Жей руг докторын сургааль үг нь сүнс талаар маш гүнзгий Бурханы үг бөгөөд их үр дүнтэй заадаг болохоор хүмүүсийн сэтгэлд гүн сэтгэгдэл ба итгэлийг суулгаж өгдөг юм. Хувь хүний сүнсний өсөлт төдийгүй улсын хэмжээнд ч маш том нөлөө үзүүлэхүйц үг юм. Енласе Колумбиа телевизээр дамжуулан И Жей руг доктор ба Манмины үйлчлэлд хамт оролцоно гэдэг үнэндээ маш сэтгэл хангалуун явдал юм.

Ялангуяа И Жей руг докторын итгэлийн амьдралтай холбогдолтой номууд нь уншигчдад гүн сэтгэгдэл төрүүлдэгээрээ онцлог юм. Юуны түрүүнд Есүс Христ бидний аврагч Эзэн болсон тухай маш тодорхой хариултыг өгсөн байдаг “Загалмайн Үг” ном нь итгэлийн амьдралийн суурь, сайн мэдээний амин чухал хэсэг гэж болох юм.

“Итгэлийн хэмжээ” ном нь явал итгэлээр өсч, төгс байдалд хүрэх, хамгийн үзэсгэлэнтэй, сүр жавхлантай тэнгэрийн орны давхарга болох Шинэ Иерусалимд хэрхэн орох тухай дамжуулж өгсөн байдаг. Мөн тэнгэрийн орны үзэсгэлэнтэй байдлыг болон тэнд эдлэх баяр хөөр, аз жаргалыг

мэдрүүлэх “Тэнгэрийн орон” 1, 2р боть, гэх мэт энэ номууд нь биднийг энэ газар дээр ийм үзэсгэлэнтэй газар руу ороход бэлтгэл хийлгэж буй хэрэг юм. Түүнчлэн И Жей руг докторын гэрчлэл ном болох “Миний амьдрал, Миний итгэл” ч үнэхээр сэтгэл хөдлөлтэйгөөр уншсан юм.

Нэг сүнсний ч там руу унахгүй байхыг хүсч буй Бурханы чин сэтгэлийг мэдрэх “Там” номноос үхлийн дараа ийм сүнсний ертөнц хүлээж байгаа болон мөн бидэнд өгөгдсөн энэ эрхэм нандин цаг хугацаанд яаж амьдрах ёстой талаар ухааруулж өгдөг юм. Тиймд энэ үг суургаалиудыг телевизээр дамжуулснаар ямар ч байсан Колумбийн ард түмэн ийм уур хилэнгээс холдуулах гэсэн сэтгэл туйлын хүсэлтэй болсон юм.

Миний хамгийн сүүлд уншсан ном бол



Саул Ринкон Енласе Колумбиа телевизийн хэлтэсийн дарга

Ул суурьтай сайхан сэтгэлийн мэргэн ухаан

“Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж. Үр жимс нь зөв байгчийн үр нь амар тайвныг бүтээгчдээр амар тайванд таригддаг юм” (Иаков 3:17-18).



Манмин төв чуулганы тэргүүн пастор,
И Жей руг пастор

- Есүс Христийн нэгдсэн ариун урсгалын ерөнхий удирдагч
- Христийн сайн мэдээ сэргэлтийн холбооны ерөнхийлөгч
- Үндэсний хайрын залбирлын нэгдсэн хорооны хамтын удирдагч
- (GCN) (Жи Си Эн) Глобал Христийн телевизийн ерөнхий захирал
- (WCDN) Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбооны ерөнхий захирал
- (MIS) Манмин олон улсын библийн их сургуулийн захирал
- Нэгдсэн ариун библийн сургуулийн захирал
- Библи судлалын доктор, Теологийн хүндэт доктор
- Христийн телевиз, радиогийн албан ёсны сургаал заагч
- Чусон илбу, Жүнан илбу, Туна илбу, Хангүг илбу, Сөүл сонин Хангёорэ сонин, Кёонхян сонин, Хангүг кёнжэ сонин, Ши са ньюс, Кристиан сонин зэрэг өдөр тутмын сонин, сэтгүүлд итгэлийн амьдралын тухай байнгын нийтлэгч
- АНУ-н Нью-Йорк, Вашингтон, Балтимор, Мерилэнд, Лос-Анжелос, Хавай, Япон, Пакистан, Филиппин, Аргентин, Гондурас, Перу, ОХУ, Герман, Кени, Танзани, Уганда, Конго бүгд найрамдах улс, Израйль Иерусалим, Эстони зэрэг улс орнуудад нэгдсэн их цуглааныг удирдан явуулсан

Бурхан Өөрийн хайрт хүүхдүүдийнхээ төлөө “Хуулийг сахь, Сайныг үйлд” гэж хичээнгүйлэн захидаг ч өчүүхэн ухаан муутай хүн өөрийн нүдэнд харагдах ашиг сонирхолоо даган өөрийн дураар амьдардаг. Харин ухаалаг хүн бол дэлхий ертөнцийн арга гэхээс илүү Бурханы аргаар өгөгдөх ерөөл нь харьцангуй том, үр дүнтэй болохыг мэддэг тул баяр хөөртэйгөөр Бурханы хуулийг сахин биелүүлж, сайныг үйлддэг.

Энэ мэт Бурханы үгийн дагуу сайныг үйлдэж, гэм хорон мууг хаян ариун байдлыг бий болгож, эв нэгдлийг хайдаг хүн нь эелдэг өршөөнгүй сэтгэл ба сайхан сэтгэлийн үр жимсийг боловсруулдаг.

1. ‘Ул суурьтай сайхан сэтгэл’-н сүнс талын утга

‘Ул суурьтай сайхан сэтгэл’ гэдэг нь сүнс талаар ‘Цайлган үзэсгэлэнтэй сэтгэлийн анхилуун үнэр ба үг яриа, үйлдлийн үр жимсээр илрэн гарах’-г хэлдэг. Зүрх сэтгэлдээ сайн ба үнэнээр дүүрэн бол гадагшаа үргэлж цайлган үгийг л гаргах үг яриа ба цайлган үйлдлийн үр жимс илэрхийлэгддэг.

Сайхан сэтгэлтэй байна гэдэг нь зүгээр л цайлган зөөлхөн байхыг хэлдэггүй. Эрч хүчтэй эр зоригтой байдаг. Сүнс талын сайн ба үнэнээр дүүрсэн сэтгэлд харанхуйг ч зайлуулах гэрлийн эрх мэдэл байдаг учраас тэр юм. Мөн бусдыг үнэн рүү хөтөлж чадах, сэтгэлээ захирахад нь ч тусалдаг. Түүнчлэн сайхан сэтгэлийн үр жимс боловсорсон Эзэний боол, ажилтан хүмүүст зөвлөгөө өгөхөд тэр үгэнд нь хүч дагалддаг.

Сайхан сэтгэлийн үр жимс боловсроогүй хүний хувьд бусад хүний бодол санаанд нийцүүлж зөвлөж өгөөд асуудал шийдэгдсэн ч тэр үедээ л болохоос төд удалгүй ижил төстэй асуудал дахин тулгарч эхэлдэг. Хичээнгүйлэн зөвлөж өгч, гэр орноор нь эргэж тойрсон ч дараа харахад буцаад анхны байдал руугаа буцаж очдог. Тийм ч учраас ул суурьтай сайхан сэтгэлийн мэргэн ухаантай байж л бусдын эргэлзээ болон өөдрөг бус бодол санааг маш оновчтой таслан зогсоож чаддаг юм. Хэдэн үг солилцоод бусдын нөхцөл байдлыг ялган таниж, бодол санааг нь тэр чигтээ сайны чиг рүү чиглүүлдэг учраас юм.

2. Илүү гүн сайны түвшин буюу сайхан сэтгэлийн гурван төрлийн шинж

1) Сайхан сэтгэлийг бий болгосон бол ямарч нөхцөлд орсон үнэнээр асуудлыг гол цөмийг таних.

Лук номын 12-р бүлэгт нэгэн хүн өв хөрөнгийн тухай асуудлаар Есүстэй уулздаг. Тэрээр эцэг эхийн үлдээсэн өв хөрөнгийг эрх тэгш хуваахыг өөрийн ахдаа хэлүүлэхийг хүссэн байдаг. Тэгтэл Есүс “Шуналын алив хэлбэрээс өөрсдийгөө хамгаал, болгоомжил. Учир нь элбэг хангалуун нэгний амь өөрийнх нь өмч хөрөнгөнөөс хамаардаггүй юм” гэж айлддаг. Шуналын сэтгэлийг хаяхгүйгээр өв хөрөнгө авлаа ч үүний дараа ах дүүгийн хооронд сэтгэл тавгуйтэх явдал гарч болзошгүй бөгөөд шунаг сэтгэлийг хаяж байж л Бурхан эд хөрөнгийн ерөөлийг өгдөг болохоор юм. Энэ мэт уг асуудлын голыг шийдэх аргыг зааж өгсөнөөр Бурханы ерөөлийг авах харилтыг хэлж өгсөн юм.

Даниел номын 5-р бүлэгт Вавилоны хаан Белшазар нь найр наадам зохиож, Иерусалимын сүмээс

олзолж ирсэн мөнгөн аяга хэрэгсэлд архи хийж уун, Вавилоны хиймэл шүтээнүүдийг магтдаг тухай гардаг. Гэтэл хааны ордны ханан дээр хүний гарын хуруу гарч ирэн, үл мэдэгдэх үсгийг бичиж гарав. Энэ үед хаан үсэг бичээд байгаа гарын хурууг хараад маш их айж гайхан сандарч, хэн нэгэн энэ үсгийг уншиж тайлж өгвөл өөрийн хаанчлалын 3-р зэргийн суудалд суулгана гэв.

Эцэст нь хаан өөрийн эцэг Небухаднезар хаанд үйлчилдэг байсан Даниелийг дуудаж тэр үсгийг тайлуулахад Бурханы өмнө маш бардам түүний үйлдэл нь энэ бүх асуудлыг шалтгаан болохыг ухааруулж өгөн, тэр бичигт хааны энэ үйлдлээс болж түүний хаанчлал улс орон Меде Персийн эрхшээлд орох болохыг мэдүүлж өгдөг. Үүнийг сонсоод Белшазар хаан өөрийн амласаны дагуу Даниелийг тансаг ухаа ягаан хувцас өмсгөн алтан гинж зүүж өгөн өөрийн хаанчлалын 3-р зэргийн суудалд суулгасан юм.

Тэгээд өөрт нь тохиолдох Бурханы шүүлтийг зогсоохын төлөө асуудлыг шийдэн гэмшихийн оронд харин ч урьдын адил зугаацаж найрласаар байлаа. Эцэстээ тэр нэг шөнө түүний хаанчлал булаагдаж амиа ч алддаг. Бурхан энэ хаанд урьдчилан сануулж, түүнийг нь Даниелийн мэргэн ухаанаар түүний учир шалтгааныг мэдэж байсан ч өөртөө тэр санамжыг авч хэрэгжүүлээгүй тул мэдсэн ч ямар ч ашиггүй байлаа.

Энэ мэт зөвлөгөө авна гэдэг нь сайн хэрэг ч өөртөө түүнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс хичнээн их байна вэ? Үнэнийг сэтгэлдээ аван үйлдсэнээр өөрөөсөө эхлэн өөрчлөгдөн сайн мэргэн ухаанаар эргэн тойрныг өөрчлөх үед гэр бүл болоод эргэн тойрны хүмүүсийг Бурханы ивээл рүү удирдах болдог.

2) Сайхан сэтгэлтэй хүн ямар ч нөхцөлд чимээгүйхэн Бурханы хүслийг ялгаж салгадаг.

Өөрийн бодсоноор ямар нэгэн ажил сайн шийдэгдэхгүй байх юм уу, эсвэл хүнд байдалд орох үед шууд тавгүй царай гаргаж барайдаг хүмүүс байна. Ингэж аягүйтэж, нүүр царай шууд хувирвал эргэн тойрны хүмүүст таагүй байдал үүсгэдэг. Ингэснээрээ асуудлыг шийдэх байтугай Бурханы хүч нөлөөг ч мэдрэх боломжгүй эргэн тойрны хүмүүст нэр хүнд алдан хөндийрүүлдэг.

Сайхан сэтгэлийг бий болгосон хүн бодит байдлаар хүнд нөхцөлд орсон ч сэтгэл санааны тайван чөлөөтэй байдлаа алддаггүй (Филиппой 4:11-13). Сандарч, гуниглан барайх бус чимээгүйхэн Бурханы хүслийг ухан ойлгох гэдэг. Бурханы ивээл дүүрэн, Бурханы хайранд бат итгэдэг тул үргэлж амгалан байдаг. Бүр цаашлаад ийм нөхцөлд ч хамгийн боломжит сайныг сонгон үйлддэг.

Мэдээж огт түгшүүргүй байна гэж байхгүй ч ямар ч үед Бурхандаа итгэж найддаг тул зүрх сэтгэлийн гүнд ганхдаггүй гэсэн үг юм. Бурхандаа чин сэтгэлээсээ найдан түшиглэх үед л Бурхан зайлшгүй гайхалтайгаар хариулж агуу алдрыг авдаг (Ром 8:28).

Итгэл бол миний хүссэн арга барилаар Бурханыг хөдөлгөхийг хүсдэг зүйл биш юм. Үнэхээр итгэлтэй бол бүх тал дээр Бурхандаа найдан түшиглэж, Түүний хүсэл юу болохыг ухаарах хэрэгтэй. Тэр хүсэл дотор өөрийн явах замыг хайж, итгэлээр урагшилахыг хэлдэг.


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг
Утас: 88107327, 91170773, 89737773

www.manmin.org
www.gcntv.org

Сайхан сэтгэлээр бүх зүйлд сэтгэл хангалуун, зөвхөн сайныг сонгон үйлдэхэд Ариун Сүнснээс урд замыг замчилж өгдөг.

Энэ бол үхлийн харанхуй хөндийгөөр туулсан ч Бурхантай хамт байгаагаар мэдэрч чадах сайхан сэтгэлийн мэргэн ухаан юм.

3) Сайхан сэтгэлийг болговол Бурханы үгийн дагуу дуулгавартай дагаж, мэдээж хийх ёстойгоосоо илүүг давуулан хийдэг.

Сайхан сэтгэлийг бий болгосон хүн нь Бурханыг хайрласнаар үгийн дагуу амьдарч, Ариун Сүнсний удирдлага дотор бүх зүйлд илүү сайныг сонгон үйлддэг. Нэгийг даалгахад Бурханы сэтгэлд нийцүүлэн хоёр, гурвыг, заримдаа түүнээс ч илүүг хийж гүйцэтгэдэг. Үүнд Бурхан “Миний сэтгэлд нийцтэй нэгэн” гэж машид баярлан таалдаг.

Итгэлийн амьдрал дунд сонголт хийх салаа зам дээр зогсох үе их байдаг. Нэг тал нь үнэн, нөгөө тал нь үнэний бус зам байвал мэдээж үнэнийг сонгодог байх хэрэгтэй. Гэхдээ хоёулаа үнэний зам бол ихэнх тохиолдолд өөрийн хүсэж буй талаа сонгодог. Гэвч сайхан сэтгэлтэй хүн нь Бурхандаа илүү алдрыг өргөх замыг сонгодог. Аль нь Бурханыг илүүтэйгээр баярлуулдаг болохыг бодон сонгохыг хэлж байгаа юм. Өмнөд Иудагийн хаант улс Вавилонд эзлэгдэх үед бага балчир насанд боолчлолд баригдан явсан Даниел ба түүний гурван найз мөн ингэсэн юм.

Даниел номын 1-р бүлэгт Даниел Вавилоны хааны ордонд идэх хоол дунд хиймэл шүтээний өмнө өргөсөн зүйл, Бурханы хориглосон бузар амьтадын мах орсон байж болох тул ордны ахлах тайганд хандан ус болон ногоо өгөхийг гуйж, хариуцсан хүндээ өөрсдийгөө арав хоногын турш ногоогоор хооллон туршихыг хүсдэг. “Энэ бол Вавилон улс, мөн яах ч аргагүй нөхцөл байдал” гэж шалтаглан ямар ч хоолноос идэж болох ч Даниел ба түүний гурван найз Бурханы хориглосон зүйлийг идэхгүй байхын төлөө сайн дураараа ногоо идэхийг гуйдаг.

Тэгээд хааны гүнцэгнээс иддэг байсан бусад хүүхдүүдээс илүү тэдний царай маш өнгөлөг жавхаатай байсан юм. Тэгвэл бусад талаар ямар болсон бэ? Бурханаас ямар ч үед илүү зөв, сайн талыг сонгоё гэж буй тэдний сэтгэлийг харж тэднийг ерөөж өгсөн юм. Сүүлд нь тэд хаанд хүлээн зөвшөөрөгдөн өндөр байр сууринд очсон юм.

Бүх тал дээр Бурханы өмнө илүү зохистой талыг сонгоно гэдэг амар зүйл биш. Илүү сайн зүйл сонгосон ч бодит байдал дээр ерөөл биш зовлон бэрхшээл ирж буй мэт харагдах үе байдаг. Тийм байсан ч гоморхох юм уу тавгүйтэх бус хангалттай даван туулна гэсэн эр зориг байх үед

л боломж бий болдог. Бурхан руу хандсан бат найдвар дээр суурилах хэрэгтэй байдаг. Даниел ба түүний найзууд ахлах тайган ба өөрсдийг нь хариуцагч нараас ингэж гуйна гэдэг нь тэд хэр зэрэг сайн итгэмжтэй болохыг харуулж байгаа хэрэг юм. Эцсийн мөчид Бурхан тэдний сэтгэлийг хөдөлгөхүйц тэд үйлс жирийн үед ч тийм байсан гэсэн үг юм.

Энэ мэт Бурханы өмнө итгэлээ харуулах үед эргэн тойрноос дэмжлэг тусламж авах үе бас байдаг. Хэрэв сүмийн чухал үйл ажиллагаанд оролцмоор байдаг, ажлын байдал болон, амралтын хуваарь таарахгүй байх юм уу гэр бүлийн уулзалт зэрэг давхцах үе байдаг. Ийм үед бусад хүлээн зөвшөөрөгдөх халамж авахын тулд жирийн үед сайныг хураах нь чухал юм. Маш шаргуу тууштай, итгэмжит ажилладаг, эргэн тойрондоо хүлээн зөвшөөрөгдсөн, бусад тавгүй сэтгэгдэл төрүүлдэггүй байх хэрэгтэй. Гэр бүлтэйгээ хамт байж чадахгүй ч сэтгэлээрээ хамт байдагаа мэдрүүлэх сэтгэл хөдлөлийг мөн тэдэндээ үзүүлдэг байх хэрэгтэй. Хэрэв өөрийн дураар үйлдэж байгаад яг хэрэгтэй үед бусадыг ойлгож өгөөч гэж хүсэх үед энэ өөрийн шунал бүдүүлэг байдал гэхээс өөр аргагүй юм.

3. Сайхан сэтгэлээр дүүрэн Элч Паул

1) Элч Паул ямар хүнийг бүдрүүлдэггүй байв.

Элч Паул Эзэнтэй уулзахын өмнө хуучин гэрээний хуулийг маш чанд сахидаг байсан ба Эзэнтэй уулзсанаас хойш сайн мэдээний төлөө өөрийн бүх зүйлийг өргөж, өөрийн эдлэж чадах байсан зүйлээ ч эдлээгүй юм. Нэг жишээ дурьдахад “Тиймээс хэрэв идэх юм миний ах дүүг бүдрүүлэх шалтаг болбол ах дүүгээ бүдрүүлэхгүйн тулд би хэзээ ч дахин мах идэхгүй” (1 Коринт 8:13) гэсэн түүний гэрчлэлийг харах боломжтой.

Элч Паулын үйлчилж байсан Коринт нь хиймэл шүтээн ихэд тархсан газар байлаа. Хиймэл шүтээнийн тахилд зориулсан мах зах дээр ч худалдах тохиолдол их байдаг байжээ. Тийм ч учраас хиймэл шүтээний өмнө тавьсан тахил болохыг ч мэдэлгүй авч идэх тохиолдол байсан тул итгэгч нар энэ нь Бурханы асуудал үүсэх үү гэдэг тал дээр мэдэхийг хүсч байлаа. Мэдээж идэхийн өмнө хиймэл шүтээнд өргөсөн тахил гэж мэдэж байгаа бол идэхгүй бол сайн бөгөөд гэвч уг зүйл нь гарал үүсэл нь тодорхойгүй тахил мөн биш болохыг ялгах боломжгүй үед идсэн ч гэм буруу болохгүй юм (Ром 14-р бүлэг). Энэ нь идэх хоол хүнс болохоос хиймэл шүтээний тахилд оролцсон явдал биш учраас юм.

Гэсэн ч итгэл сул дорой хүмүүс идэх юмнаас

болж бүдэрч болзошгүй ба итгэл сайтай хүний идэж буйг хараад хиймэл шүтээнд үйлчилж буй мэтээр бодож дүгнэж шүүж ч болзошгүй юм. Магадгүй “Элч Паул шиг хүн энэ мэт хиймэл шүтээний тахил идэж байгаа бол би ч гэсэн болно” гээд ямар ч эргэлзээгүй идэх болдог. Уг нь элч Паул хичнээн л бол итгэлээрээ идэж болох ч магадгүй үүнийг хараад бүдрэх нөхцөл бүрдвэл харин ч идээгүй байсан нь дээр гэсэн байдаг. Хэдийгээр мөнхөд мах идэхгүй байлаа ч хүмүүсийн сүнснийг бүдрүүлэхгүй талыг сонгоно болно гэсэн үг юм.

2) Элч Паул өөрийн мэдээж эдлэх ёстой эрх мэдлээ ч ашиглаагүй юм.

Элч Паул сайн мэдээг тараах үйлсэд бэрхшээл учруулахгүйн тулд бусад хүмүүс шиг итгэлээрээ идэж уух эрх мэдэл, хуримлах ч юм уу ийм зүйлийг хэрэглээгүй юм. Мөн тэрээр ажил ч хийлгүй мэдээж өөрийн эдлэх ёстой эрх мэдлээсээ ч зайлсхийсэн байдаг. Зарчмын хувьд Эзэний боол нь үг сургааль ба залбиралд өөрийгөө бүрэн зориулахын тулд итгэгч нарын дэмжлэгээр хэрэгтэй бүхнээрээ хангагддаг. Гэтэл Паул өөрөө ажил хиймэгцээ өөрийн хэрэгцээг хангаж байлаа. Түүний ингэх нь маш олон шалтгаан байсан ч юуны өмнө итгэгч нарт ачаа дарамт болохыг хүсээгүй учраас юм.

Бурхан үүнд баярлан таалж, бусад элч нараас илүү их эрх мэдэлт хүчийг үйлдүүлэх болдог. Тод онгод ба мэргэн ухааныг өгч, итгэгч нарт мэргэн ухаанаар маш тодорхой хариултуудыг өгч байлаа. Мөн ийм агуу хүч нөлөөгөөр үй олон хүмүүсийг аварч Бурханы хүсч буй арга барилаар дагуулж байлаа.

Энэ мэт сайхан сэтгэлийн төгс өөртөө бий болгосон хүн үргэлж сайны талыг сонгодог. Ямар нэг зорилгоор, эсвэл хэн нэгэн харж байгаа учраас бус Бурханыг л илүү ихээр баярлуулахын тулд юм. Зүрх сэтгэлд дүүрэн сайны үг яриа үйлдэл дунд аяандаа гардаг гэсэн үг юм. Эзэний боол юм уу ажилтан нь илүү ихээр сайхан сэтгэлийг бий болгох хэрэгтэй юм. Бүх зүйлд үлгэр жишээ болох ёстой ч хиймээр буй зүйлээ хийж чадахгүй үед ч, заавал хийгээд байх шаардлагагүй ч Бурханы алдрын төлөө хийх ёстой зүйл ч бас байдаг.

Хайрт итгэгч та бүхэн, Хожим мөнхийн тэнгэрийн оронд очих үед үзэсгэлэнтэй орон байр ба шагналыг хүсэн тэмүүлж, бидний өчүүхэн хүслийг ч санаж байдаг Бурхан Аавдаа бид нулимс унаган талархал хайрыг гэрчлэл өргөх болно. Тэр өдрийг бодон Бурханыг баярлуулах талыг үргэл сонгодог сайны мэргэн ухааныг авч хамгийн үзэсгэлэнтэй Шинэ Иерусалим хотод орж ирэхийг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

“Манмины зуны цуглаанд яваад хариулт ерөөлөөр дүүрэн байна”



Юулия Корелруба итгэгч (42нас, Англи)



2008онд TBN Россия телевизээр дамжуулан И Жей руг пасторын сургаалыг сонсч эхэлсэн ба түүний дараахан манай гэр бүл интернэтээр Манмин төв сүмийн мэргэл ба залбиралд оролцдог болсон. 2011онд цагаачлан ирсэнээс хойш 4жил болж, цагаачлах эрх авч чадалгүй байдал бүрхэг байсан ч И Жей руг пасторын залбирлыг авч түүний дараахан удалгүй цагаачлах эрхээ авсан гайхалтай зүйл тохиолдсон юм. 2013оноос жил бүр “Манмин бүх итгэгчдийн зуны цуглаан”-д оролцоор ирсэн юм.

Ялангуяа 2016оны “Манмин бүх итгэгчдийн зуны цуглаан”д оролцоод том хүүгийн ганихрах өвчин эдгэрсэн гайхалтай үйл явдал болсон юм. Хүү маань юунд ч хамаагүй толгойгоо цохин мөргөж, орилж хашгиран уурладаг байлаа. Эцэг эхийнхээ үгийг ч авахгүй эргэн тойрноо ч мэдрэх

чадваргүй байлаа. Яг л амьтан шиг дуугарч юу ч ярьдаггүй байсан юм. Гэтэл И Жей руг пасторын залбирлыг авсанаар орилж хашгирахгүй болж, миний болон аавын үгэнд хариулдаг болсон. Хаалгаа хаа гэвэл хааж, бороо орж байвал “Бороо” гэж хэлдэг, ямар хоол болохыг ялгаж ярьдаг хүртэл болсон юм. 2017 “Манмин бүх итгэгчдийн зуны цуглаан”д оролцоод залбирал авсаны дараа нурууны бүсээ ганцаараа бүсэлж, ааваа ээжээ гэж хэлэх төдийгүй өөрийгөө илэрхийлэх гэх мэт өмнөхөөсөө эрс дээрдсэн юм. Халлелуяа!

Том хүү маань үнэхээр их дээрдэж, 2018онд хоёрдох хүүтэй хамт ирсэн юм. Хариулт ба ерөөлөөр бялхсан “Манмин бүх итгэгчдийн зуны цуглаан”д энэ жил ч оролцоод маш аз жаргалтай байлаа.

URIM BOOKS

Мэргэн ухааны үүдийг нээх түлхүүр бол Ариун байдал
Жинхэнэ мэргэн ухаан бол толгойноос бус зүрх сэтгэлээс гардаг.

“Манмин сүмд ирээд миний амьдрал өөрчлөгдөж, ээж минь дахин сэргэсэн”

Беатрисе Коринбэ Охана итгэгч (61нас, Мексик)



Би Эзэнийг хүлээн аваад сүнсний нүд нээгдэх зэрэг янз бүрийн сүнслэг зүйлийг мэдэрсэн. Гэвч 10-д жил сүмүүдийн дэг журамгүй хэт туйлширсан сургаалидаар юу нь жинхэнэ зам болохыг ухаарч чадаагүй тул бүлээхэн итгэлээр амьдарч байлаа.

Тухайн үед нөхөр архинд донтсон байдалтай, ямар ч номлогч миний хэрэгцээ хариултад хариу өгч чадахгүй би хэрхэн асуудлаа шийдэх ёстойгоо ч мэдэлгүй бүрхэг зовиур дунд амьдардаг байлаа. Гэтэл сайн Бурхан Аав миний итгэлийг алдуулахгүй тулд том ивээлийг бэлдсэн байсан юм.

2010оны нэг өглөө өглөө үүрээр сэрээд гэнэт телевиз асаамаар санагдаж, тэр Енласэ (Enlace) (Испани хэл дээр Христийн суваг)-р И Жей руг пасторын сургаалийг сонсч эхэлсэн юм. Би тэр сургаалийг сонсч эхэлмэгц тэр сургаалийн миний хайж байсан жинхэнэ сургааль болохыг ухаарч тэр жилдээ багтааж И Жей руг пасторын 500-гаад сургаалийг сонссон юм.

Мөн И Жей руг пасторын ном “Загалмайн үг”, “Тэнгэрийн орон”, “Там”, “Сүнс, Бие Сэтгэл”, “Сэрэгтүн Израйль”, “Эрх мэдэлт хүч” зэрэг уншиж маш ивээл авсан юм. Нэг нэг сургаалиар дамжуулан юу нь сайн болон хорон муу болохыг, яагаад тэр хугацаанд сүнс талаар өсч чадаагүй талаар ухаарсан юм. Миний амьдрал өөрчлөгдөн, гэр бүлийн асуудал ч шийдэгдсэн юм. Интернетээр өдөр бүр Манмин төв сүмийн даниел залбирлын цагт залбирах тул үнэхээр аз жаргалтай байна.

2015онд Манмин төв сүмийн 33жилийн ойн баярт оролцохоор Солонгост очсон нь миний хүсэл биелэгдсэн юм. Тэр миний баруун өвдөгний холбоос шөрмөс гэмтэж хагалгаанд орох ёстой байсан ч И Жей руг пасторын залбирлыг шууд авсанаар төгс

эдгэрч, хагалгаанд орох хэрэггүй болсон юм. Халлелүяа!

2018оны эхээр И Жей руг пасторын залбирал хийж өгсөн алчуур (Үйлс 19:11-12)-г авсан би бас нэг гайхалтай хүч нөлөөг мэдэрсэн юм. Өнгөрсөн 6-р сард нэг төрлийн сэтгэцийн өвчнөөр зовиурлаж байсан ба дээрээс нь уушгины сүрьеэ өвчин хүндэрч тархин дах хүчил төрөгчийн хангамж 60% төдий болсноор биеийн дархлааны чадвар унаж 14хоногийн турш үхэл амьдралийн зааг дээр байлаа.

Би эрх мэдэлт хүчтэй гар алчуурыг ээж дээрээ тавьж өдөр шөнөгүй залбирч, бачимдсан сэтгэлдээ ээждээ муухай аашилж хатуу хандаж байсандаа гэмшсэн юм. Түүний дараахан дахин сэргэхэд хэцүү гэж байсан бие нь сайжирч, ээжийн бие дэх идээт үрэвсэл төдийгүй уушгины сүрьеэ өвчин нь хүртэл төгс эдгэрч, ой ухаан нь сэргээд ирсэн юм. Сэтгэцийн асуудал ч мөн дээрдсэн юм.

Тэр хугацаанд би Бурханы хүслийг даган Мексикт И Жей руг пасторын номыг түгээсээр ирсэн бөгөөд цаашид ч үргэлжлүүлэн Испани, Франц, хэл дээрх шинэ номуудыг олон хүмүүст дамжуулах бодолтой байна. Учир И Жей руг пасторын ном нь надад эрдэнэс мэт билээ.

Энэ нь миний доторх харанхуйг мэдрүүлж, тэгэх тусам илүү их өөрчлөгдөх хүслээр дүүрч бялхдаг. Ариун байдалд хүрсэн амьдрал ба тэнгэрийн орныг хүсэн тэмүүлэх хүсэлийг өгч, мөн итгэлээр өсгөж, Христ дотор бие биенээ хайрлахад тус дэм болж байдаг.

Сүнс талаар сульдаж туйлдсан эцсийн үед жинхэнэ үнэнийг тунхаглаж мэдүүлж өгдөг эрхэм хоньчинтой уулзуулж өгсөн Ариун Гурвал Бурхандаа бүх талархал алдрыг өргөө.

Би бага байхаасаа олон цуглаанд явдаг байсан ч жинхэнэ Бурханыг таньж чадахгүй зүгээр л аавыгаа дагаж явдаг итгэлтэй байлаа.

Тэгж байгаад 2009онд манай гэрийнхэн ТВН Россия (Орос хэл дээрх Христийн суваг)-р И Жей руг пасторын сургаалийг сонсч эхэлсэн юм. Тэр сургаал үг маш ивээлтэй байсан тул интернетээр Манмин төв сүмийн сайтыг хайж бусад сургаалиудыг сонсдог болсон юм.

И Жей руг пасторын сургаалийг сонсох юм уу мөргөлийн цагт шууд оролцоход маш халуун байдал уур амьсгал чин шударга хүн мэт санагдсан. Чин сэтгэлээр Бурханыг хайрлана гэдэг юу болохыг ухаарч гэр бүлээрээ тэр үгийн дагуу амьдрах гэж хичээх тусам аав (Антон Дегу) ын минь ажил өргөжин арвин их ерөөл авсан юм.

2015онд би ахлах сургуульд байхдаа долоо хоногын сүүл болвол найзуудтай гадуур зугаалдаг байсан ч үүнээс илүү мөргөлд оролцоход илүү дуртай байлаа.



“Эзэний үг миний хөл дэх дэнлүү, миний замыг гэрэлтүүлэгч”

Сусанна Мечи (20нас, Украин)



Сургаалийг сонсч, амралтын өдрийг ариунаар сахиж, арван нэгийн өргөлөө төгс өргөж байж Бурханаар хамгаалалтад байж, ерөөгддөг болохыг сурсан учраас юм.

Мөн ‘Хичээл сайн хийх арга’ гэдэг сургааль сонсож түүний дагуу хичэлээ идэвхитэй хийснээр Харьков хотын Анагаах ухаан их сургуульд өндөр үнэлгээтэйгээр элсэн орж чадсан юм. Тэргүүн пастор хичээлээ сайн хийснээрээ Бурхандаа алдрыг өргөх хэрэгтэй гэсэн тул хэцүү байсан ч энэ тэр үгийн дагуу хичээнгүйлэн хийсэн юм.

Одоо ч хичээл хийх болгондоо Бурханы хамт оршин байгааг болон түүний тусламж олон удаа мэдэрч байна. Ялангуяа 2018онд маш чухал шалгалт өгөх үед тааварлаж байсан шалгалтын асуултууд ирсэнээр бүх тал дээр сайн үнэлгээ авч, бүтэн тэтгэлэг авах боломжтой болсон юм.

Би энэ талаар байнга боддог. ‘Хэрвээ би тэргүүн пастортай уулзаагүй байсан бол, жинхэнэ үнэнийг ухаарч чадаагүй бол би хаана юу хийж яваа бол доо? би Бурханд итгэх байсан болов уу? Аврал хүртэх байсан болов уу?’ гэж боддог байв.

Харин одоо мөнхийн үнэнийг мэддэг болж, тэнгэрийн орон ба тамыг оршин байдагт багтай итгэж энэ ертөнцийн амьдрал түр зуурынх бөгөөд хоосон болохыг ухаарсан юм. Ертөнцийн зүйлд авталгүй гал мэт залбирлаар гэм нүглээ хаяад ариун байдлыг олон хамгийн үзэсгэлэнтэй Шинэ Иерусалимд мөнхөд аз жаргалтай амьдрах нь жинхэнэ үнэн болохыг ухаарсан юм.

Манай гэр бүлийнхнийг хайрлаж, ерөөж өгсөн сайн Бурхандаа, Эзэндээ талархал алдрыг өргөө. Бурханы жинхэнэ үр хүүхэд болох хүртэл удирдаж өгсөн тэргүүн пастордаа баярлалаа.

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manmininen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин